

## ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.ДЭЛГЭРСАЙХАНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит болон ээлжит бус дараах хурлуудад цахимаар оролцох болон тогтоолын төсөлд бичгээр саналаа өгөх хэлбэрээр холбогдох шийдвэр гаргахад саналаа өгч ажилласан.

### **1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлууд дараах хугацаанд хуралдав.**

- 1.1. 2024.01.24-ний өдөр;
- 1.2. 2024.02.07-ны өдөр;
- 1.3. 2024.02.19-ний өдөр;
- 1.4. 2024.02.28-ны өдөр;
- 1.5. 2024.03.07-ны өдөр;
- 1.6. 2024.03.18-ны өдөр;
- 1.7. 2024.03.27-ны өдөр;
- 1.8. 2024.04.05-ны өдөр;
- 1.9. 2024.04.12-ны өдөр;
- 1.10. 2024.05.09-ны өдөр;
- 1.11. 2024.05.22-ны өдөр;
- 1.12. 2024.06.06-ны өдөр;
- 1.13. 2024.06.14-ны өдөр.

### **2. Аудитын хорооны хурал дараах хугацаанд хуралдав.**

- 2.1. 2024.02.08-ны өдөр.
- 2.2. 2023.05.17-ны өдөр

### **3. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал хуралдсан байдал.**

- 3.1. 2024.02.02-ны өдөр;
- 3.2. 2024.04.10-ны өдөр;
- 3.3. 2024.06.05-ны өдөр;

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө хууль дээдлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэх, хамгаалах зарчимд үндэслэн Компанийн тухай хууь, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. ХХБ-аас 2024 онд баримтлах Эрсдэлийн аппетитыг батлах;
2. Банкны хөрөнгө оруулалттай компанийн ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлуудад оролцох, шийдвэр гаргах, холбогдох бичиг баримтанд гарын үсэг зурах эрх олгох;

3. ДАГ-ын 2024 оны аудитын төлөвлөгөөг батлах;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, улирал, жилийн гүйцэтгэлтэй танилцах, үнэлгээ дүгнэлт гаргах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ХХБ-ны засаглалтай холбоотой бодлого, журмуудыг батлах;
7. ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
8. Банкны тогтворжуулах төлөвлөгөөг батлах;
9. ХББ-ны 2023 оны аудитлагдсан тайланг хүлээн авах;
10. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг шийдвэрлэх;
11. ХХБ-ны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох, гэрээ байгуулах зөвшөөрөл өгөх;
12. Банкны бүтцэд өөрчлөлт оруулах;
13. Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах;
14. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт татах зөвшөөрөл олгох зэрэг асуудлууд болно.

#### Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй 7 хэлцлүүд ТУЗ-н хурлаар орж хэлэлцэгдсэн, тухай бүрд хуралд оролцож өөрийн саналыг өгч оролцлоо. Эдгээр сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хэлэлцэх явцад ТУЗ-н хараат бус гишүүний үүргийн хүрээнд хууль эрх зүйд нийцтэй байдал, Монголбанкны тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах байдал, комплайнсын хүрээнд нийцтэй зэргийг тодруулж, тайлбар авч ажиллалаа.

Тайлант хугацаанд хуралд оролцоходоо дараах чиглэлээр асуулт асуух, санал, зөвлөмж хэлэх, үүрэг даалгавар өгөх байдлаар ажиллалаа. Үүнд:

- *Банкны үйл ажиллагаа удирдлага зохион байгуулалт,*
- *Банкны бодлого, стратеги, төлөвлөлт хэрэгжилтийн асуудлаар;*
- *Банкны үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын чиглэлээр;*
- *Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, түүний хяналт, үнэлгээний асуудлаар;*
- *Дотоод аудитын үйл ажиллагаа, тайлагналыг сайжруулах хүрээнд;*
- *Банкны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-н зүгээс өгөх дүгнэлтийн хүрээнд;*
- *Хувьцаат компанийн хувьд ногдол ашиг хуваарилалт, хуваарилалтын бодлогын хувьд;*
- *ТУЗ-н дэргэдэх хороо, ажлын албаны дүрэм журамдын хүрээнд;*
- *Компанийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний тайлангийн үр дүн, түүнд оролцох ТУЗ-н оролцооны талаар;*

Мөн аудитын хорооны дарга, эрсдэлийн хорооны гишүүний хувиар дараах чиглэлд анхааран ажиллалаа. Үүнд:

- *Аудитын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сайжруулах тайланг илүү үр дүнтэй болгох*
- *Аудитын хорооны дүрмийг Компанийн засаглалын кодекс, СЗХ-ны шаардлагад нийцүүлэн өөрчлөх асуудал*
- *2023 оны ICAAP, ILAAP тайлангийн үнэлгээ;*
- *Банкны тогтворжуулах төлөвлөгөө, эрсдэлийн аппетит;*

ТУЗ, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Аудитын хорооны даргаар ажиллахдаа Компанийн хууль, Банкны тухай хууль, МБ-ны журам, ХХБ-ны дүрмийг мөрдлөг болгон банкны үйл ажиллагаатай холбоотой ТУЗ, Гүйцэтгэх Удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зэрэг ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК**  
**ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.БОЛОРМААГИЙН**  
**2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо (ЦУНДХ)-ны дарга, Аудитын хороо (АХ)-ны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, ЦУНДХ, АХ-ны ээлжит болон ээлжит бус хурлуудад цахимаар, бичгээр санал өгөх аргаар оролцож, холбогдох асуудалд саналаа өгч ажилласан.

**1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дараахь хугацаанд хуралдав.**

- 1.1. 2024.01.24-ний өдөр;
- 1.2. 2024.02.07-ны өдөр;
- 1.3. 2024.02.19-ний өдөр;
- 1.4. 2024.02.28-ны өдөр;
- 1.5. 2024.03.07-ны өдөр;
- 1.6. 2024.03.18-ны өдөр;
- 1.7. 2024.03.27-ны өдөр;
- 1.8. 2024.04.05-ны өдөр;
- 1.9. 2024.04.12-ны өдөр;
- 1.10. 2024.05.09-ны өдөр;
- 1.11. 2024.05.22-ны өдөр;
- 1.12. 2024.06.06-ны өдөр;
- 1.13. 2024.06.14-ны өдөр.

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах;
2. Худалдаа, хөгжлийн банкны 2023 оны 1-р улирлын гүйцэтгэлтэй танилцах;
3. Худалдаа, хөгжлийн банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлантай танилцах;
4. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
5. Худалдаа, хөгжлийн банкны хөрөнгө оруулалттай компаниудын 2024 онд хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлуудад банкныг төлөөлөн саналын эрхтэй оролцох, шийдвэр гаргах болон холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг банкны холбогдох албан тушаалтанд олгох;
6. Аудитын хорооны дүрэмд өөрчлөлт оруулах;

7. Худалдаа, хөгжлийн банкны үндсэн хөрөнгө, БЗХ, зээлийн өр төлбөрт тооцон хураан авсан ӨБХХ, ӨБҮХХ-д бүртгэлтэй хөрөнгүүдийг зарах зөвшөөрөл олгох;
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах;
9. Худалдаа, хөгжлийн банкны 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд үнэлэлт, дүгнэлт өгөх;
10. Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэх бусад асуудал.

Тайлант хугацаанд ЦУНДХ нь нийт 6 удаа хуралдаж, банкны ГЗТО, ГЗО нарыг ТУЗ-өөс томилдог байх, гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээний санал, ТУЗ-ийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн хорооны гиүүн томилох, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2024 оны эхний хагас жилд Аудитын хороо нь нийт 2 удаа хуралдаж, Аудитын хорооны дүрэмд оруулах өөрчлөлт, Дотоод аудитын газрын 2023 оны ажлын нэгдсэн тайлан, 2024 оны аудитын ажлын төлөвлөгөөний төсөл, 2024 оны 1-р улирлын ажлын тайлантай танилцах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хурлаас гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, банканд ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхийг зорьж ажилласан болно.

#### Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан. Тайлант хугацаанд буюу 2024 оны эхний хагас жилд нийт 7 сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай асуудалд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан. Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал ТУЗ-ийн хуралд танилцуулагдаагүй.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан гишүүний эрх, чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд аливаа зөрчил, дутагдлыг арилгах, хяналт тавих хүрээнд тавьсан шаардлага байгаагүй ба хэлэлцсэн асуудлаар тавьсан саналыг ТУЗДАА болон Банкны удирдлага, газар нэгжүүд хүлээн авч тухай бүр засаж залруулж, хэрэгжүүлж явсан бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

Ж.Болормаа

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК**  
**ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН З.НАРАНТУЯАГИЙН**  
**2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурал, Эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны дараах хурлуудад оролцож, холбогдох шийдвэрүүд гаргахад саналаа өгч ажилласан.

**1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал**

- 1.1. 2024.01.24-ний өдөр;
- 1.2. 2024.02.07-ны өдөр;
- 1.3. 2024.02.19-ний өдөр;
- 1.4. 2024.02.28-ны өдөр;
- 1.5. 2024.03.07-ны өдөр;
- 1.6. 2024.03.18-ны өдөр;
- 1.7. 2024.03.27-ны өдөр;
- 1.8. 2024.04.05-ны өдөр;
- 1.9. 2024.04.12-ны өдөр;
- 1.10. 2024.05.09-ны өдөр;
- 1.11. 2024.05.22-ны өдөр;
- 1.12. 2024.06.06-ны өдөр.

**2. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал**

- 2.1. 2024.02.02-ны өдөр;
- 2.2. 2024.04.10-ны өдөр;
- 2.3. 2024.06.05-ны өдөр.

**3. Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хурал**

- 3.1. 2024.01.23-ны өдөр;
- 3.2. 2024.03.04-ний өдөр
- 3.3. 2024.05.06-ны өдөр;
- 3.4. 2024.05.15-ны өдөр.

Энэхүү хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

### **ТУЗ-ийн хурлаар:**

1. Санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын байгууллагыг сонгох;
2. Хувьцаа эргүүлэн худалдах зөвшөөрөл олгох;
3. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг шийдвэрлэх;
4. Худалдаа, хөгжлийн банкны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой бодлого, журам, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах;
5. Худалдаа, хөгжлийн банкны хөрөнгө оруулалттай компаниудын 2024 онд хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлуудад банкныг төлөөлөн саналын эрхтэй оролцох, шийдвэр гаргах болон холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг банкны холбогдох албан тушаалтанд олгох;
6. Худалдаа, хөгжлийн банкны үндсэн хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө, өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн үнийг тогтоож, худалдан борлуулах зөвшөөрөл олгох;
7. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах зөвшөөрөл олгох;
8. ДАГ-ын удирдлагын томилгоо;
9. ДАГ-ын цалингийн зэрэг тогтоох, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулах болон бусад асуудал.

### **Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар:**

1. Худалдаа, хөгжлийн банкны 2024 онд баримтлах эрсдэлийн аппетит;
2. Худалдаа хөгжлийн банкны Тогтворжуулах төлөвлөгөө 2024 болон ХХБ-ны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг длгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны 2023 оны 4-р улирлын тайлан зэрэг асуудлыг хэлэлцсэн.

### **Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хурлаар:**

1. ТУЗ-ийн дэргэд Тогтвортой хөгжлийн хороо байгуулах тухай санал;
2. Гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээний санал;
3. Иргэдийн бизнес хариуцсан ГЗО-той байгуулсан гэрээний хугацааг сунгах санал зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн болно.

Дээр дурдсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй бөгөөд хууль тогтоомжид нийцсэн шийдвэрүүд байсан гэж үзэж байна.

### **Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл:**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан. Тайлант хугацаанд долоон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл хүссэн асуудалд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан. Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал ТУЗ-ийн хурлаар хэлэлцэгдээгүй.

ТУЗ түүний дэргэдэх хороодын дарга, гишүүнээр ажиллахдаа төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь улс төрийн, том хувь нийлүүлэгчдийн нөлөөлөл болон бусад гаднын зохисгүй нөлөөнөөс үл хамааран Худалдаа, хөгжлийн банкны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавьж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Банкны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч Банк болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Худалдаа, хөгжлийн банкны

ТУЗ-ийн хараат бус гишүүн

З.Нарантуяа